

ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн “Буйр нуурын экосистемийг хамгаалах, аялал жуулчлал хөгжүүлэх төв”  
ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДОА-2026/003/НА-СТА-ОНӨҮГ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Чойбалсан хот <b>2026 он</b></p>	<p>Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: Д.Нармандах Утас: 7058-4204, Цахим хаяг: narmandakh@audit.gov.mn Аудитор: Б.Одхүү Утас: 7058-4207, Цахим хаяг: odkhuu@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5-7
3. Аудитын илрүүлэлт .....	8
4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	9

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
НА	Нийцлийн аудит
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Баянтүмэнгийн гудамж, 9 дүгээр баг  
Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000  
Утас: 7058-4203

ДААБ.03.16 № 370

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ДОРНОД АЙМГИЙН БУЙР НУУРЫН  
ЭКОСИСТЕМИЙГ ХАМГААЛАХ, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛ ХӨГЖҮҮЛЭХ ТӨВ  
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА Т.ДАШ-ЭРДЭНЭ  
ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дорнод аймгийн "Буйр нуурын экосистемийг хамгаалах, аялал жуулчлал хөгжүүлэх төв" ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу үнэлсэн, нөлөө бүхий эрсдэлтэй удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал үйл явдал гараагүй болно.

### Бусад асуудлын хэсэг

Дорнод аймгийн "Буйр нуурын экосистемийг хамгаалах, аялал жуулчлал хөгжүүлэх төв" ОНӨААТҮГ нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 30 арга хэмжээг төлөвлөж биелэлтийг 78.1 хувиар дүгнүүлсэн байна.

2126050105

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	28,028.93	24,810.93
1.1.2	Дансны авлага	-	-
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	-	-
1.1.6	Бараа материал	2,334,000.00	6,183,500.00
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>2,362,028.93</b>	<b>6,208,310.93</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	58,750.00	43,750.00
1.2.2	Биет бус хөрөнгө	1,175,000.00	875,000.00
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>1,233,750.00</b>	<b>918,750.00</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,595,778.93</b>	<b>7,127,060.93</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>ӨР ТӨЛБӨР</b>	-	-
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>	-	-
2.1.1.1	Дансны өглөг	-	-
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	-	-
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	-	-
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	-	-
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч : а) Орон нутгийн өмч	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	3,595,778.93	7,127,060.93
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>3,595,778.93</b>	<b>7,127,060.93</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР ЭЗЭМШИГЧДИЙН</b>	<b>3,595,778.93</b>	<b>7,127,060.93</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого /цэвэр/	103,459,500.00	155,698,300.00
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-	-
<b>3</b>	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>103,459,500.00</b>	<b>155,698,300.00</b>
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүний орлого	-	-
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	-	3,000,000.00
9	Борлуулалт маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	102,267,072.00	155,167,018.00
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	-	-
17	Бусад ашиг /алдагдал/	-	-
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>1,192,428.00</b>	<b>3,531,282.00</b>
19	Орлогын татварын зардал		
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>1,192,428.00</b>	<b>3,531,282.00</b>
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг /алдагдал/	-	-
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>1,192,428.00</b>	<b>3,531,282.00</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>103,459,500.00</b>	<b>158,698,300.00</b>
	Бараа борлуулсан үйлчилгээний орлого	103,459,500.00	155,698,300.00
	Бусад мөнгөн орлого		3,000,000.00
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>103,442,072.00</b>	<b>158,701,518.00</b>
	Ажиллагчдад төлсөн	87,978,628.00	126,388,756.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	10,249,178.00	14,963,482.00
	Бараа материал худалдан авахад төлсөн	3,175,166.00	
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд		3,100,000.00
	Даатгалын төлбөрт төлсөн		
	Бусад мөнгөн зарлага	2,039,100.00	14,249,280.00
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн</b>	<b>17,428.00</b>	<b>(3,218.00)</b>
	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>2</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>		
<b>2.1</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>		
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>		
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр</b>		
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>		
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>		
	Зээл авсан, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>17,428.00</b>	<b>(3,218.00)</b>
<b>5.1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>10,600.93</b>	<b>28,028.93</b>
<b>5.2</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>28,028.93</b>	<b>24,810.93</b>

### 2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>1</b>	<b>2024 оны 12-р сарын 31 -ний үлдэгдэл</b>	-	-	-		<b>2,403,350.93</b>	<b>2,403,350.93</b>
<b>2</b>	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга						-
<b>3</b>	<b>Залруулсан үлдэгдэл</b>					<b>1,192,428.00</b>	<b>1,192,428.00</b>
<b>4</b>	<b>2025 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл</b>					<b>3,595,778.93</b>	<b>3,595,778.93</b>
<b>5</b>	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	3,531,282.00	<b>3,531,282.00</b>
<b>6</b>	Бусад дэлгэрэнгүй орлого						-
<b>7</b>	Өмчид гарсан өөрчлөлт						-
<b>8</b>	Зарласан ногдол ашиг						-
<b>9</b>	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						-
<b>10</b>	<b>2025 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл</b>	-	-	-	-	<b>7,127,060.93</b>	<b>7,127,060.93</b>

**2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

№	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>155,700,000.00</b>	<b>158,701,518.00</b>
3	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>155,700,000.00</b>	<b>158,701,518.00</b>
4	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>155,700,000.00</b>	<b>158,701,518.00</b>
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	125,499,605.00	126,388,756.00
6	Үндсэн цалин	125,499,605.00	126,388,756.00
11	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,858,948.00	14,963,482.00
12	Тэтгэврийн даатгал	15,858,948.00	14,963,482.00
22	Хангамж, бараа материалын зардал	4,624,447.00	4,652,200.00
23	Бичиг хэрэг	550,000.00	535,200.00
24	Тээвэр, шатахуун	3,100,000.00	3,100,000.00
25	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	660,000.00	715,000.00
28	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	314,447.00	302,000.00
30	<b>Нормативт зардал</b>	<b>2,800,000.00</b>	<b>2,800,000.00</b>
32	Хоол, хүнс		
33	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,800,000.00	2,800,000.00
34	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,000,000.00</b>	<b>5,000,000.00</b>
38	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00
43	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,917,000.00</b>	<b>4,897,080.00</b>
45	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,372,000.00	1,372,000.00
46	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр		3,000,000.00
47	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	45,000.00	30,580.00
49	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450,000.00	440,000.00
51	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	50,000.00	54,500.00
53	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-
66	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	-
70	Бусад урсгал шилжүүлэг	-	-
94	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>155,700,000.00</b>	<b>158,700,000.00</b>
95	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	-
100	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	155,700,000.00	155,700,000.00
101	Орон нутгийн төсвөөс	155,700,000.00	155,700,000.00
108	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	-	3,000,000.00
110	Туслах үйл ажиллагааны орлого		3,000,000.00
115	<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>	-	-
120	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	28,028.93
121	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	24,810.93
122	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>		
123	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1	1
124	ОНӨААТҮГ	1	1
126	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	7	7
127	Удирдах ажилтан	1	1
128	Гүйцэтгэх ажилтан	6	6

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 9.2 сая төгрөгийн 6 зөрчил<sup>1</sup> илэрснээс 9.2 сая төгрөгийн 2 албан шаардлага, 4 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 9,200.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 3,000.0 мянган төгрөгөөр илүү боловч Завсрын аудитаар өгсөн 6.2 сая төгрөгийн 1 албан шаардлагыг хэрэгжүүлсэн тул *Өөрчлөлтгүй* дүгнэлт өглөө.

#### 3.1 Албан шаардлага

1. Тайлант хугацаанд тус байгууллага нь Төрийн банкнаас өгсөн 3.0 сая төгрөгийн урамшууллыг байгууллагын хамтын санд гэж зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх "Энэ хууль нь төсвийн байгууллага, түүний албан тушаалтан, Засгийн газрын болон орон нутгийн тусгай сан, төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлдэг болон хууль тогтоомжийн дагуу төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээдэг төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд хамаарна", 4.1.4 дэх "орлого" гэж тухайн этгээдийн дотоод гүйлгээнээс бусад гаднаас хүлээн авах бүх төрлийн гүйлгээг", 23.5.2 дахь "төрийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "15.1.Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3-д "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэж заасныг мөрдөж ажиллаагүй *нийцсэн бөгөөд зохистой байх* батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Бараа материалын хагас жилийн тооллогыг хийгээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана", 70.2.2-т "түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/" хийж тайлагнана гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

#### 3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

*Илрүүлэлт 1:* Буйр нуурын экосистемийг хамгаалах аялал жуулчлалыг хөгжүүлэх төв ОНӨААТҮГ-ын ажиллах дүрмийг аймгийн ИТХ-ын 2023 оны 17/01 тоот тогтоолоор баталсан. Дүрмийн 2.2 -д "Газар нь Дорнод аймгийн Халхгол сумын Ялалт багт байрлаж үйл ажиллагаа явуулна" гэж заасан боловч тус багт өөрийн гэсэн байртай болоогүй байна. Тус багт ажилладаг байгууллагын 3 албан хаагч нь ажлын цагийн бүртгэлийг гар утсаар дамжуулан бүртгүүлдэг тул үйл ажиллагааг хэвийн чиг үүргийн дагуу үр дүнтэй зохион байгуулж байгаа нь эргэлзээтэй байна.

*Өгсөн зөвлөмж:* Үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах, ажлын цагийн бүртгэлийг хууль журмын дагуу бүртгэх.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Баримтлах бодлого чиглэл, хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар

**Илрүүлэлт 2:** Тус байгууллага нь өөрийн орлогыг төлөвлөдөггүй, үйл ажиллагааны зардлыг орон нутгийн төсвөөс 100 хувийн татаас аван санхүүжүүлж байгаа ч улсын бүртгэлд Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газраар бүртгүүлсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-д "Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Өөрийн орлогын төлөвлөгөөг батлуулж, байгууллагын үйл ажиллагааны үр ашгийг тодорхойлж ашигт ажиллагааны түвшинг тооцож ажиллах.

3. Байгууллагын үйл ажиллагааны талаар

**Илрүүлэлт 3:** Дорнод аймгийн Халхгол суманд Байгаль орчны чиглэлээр Буйр нуур Мэнэнгийн талын сав газрын захиргаа, Нөмрөгийн дархан цаазат сав газрын захиргаа, Халхгол сумын Сум дундын ойн анги, Буйр нуурын экосистемийг хамгаалах, аялал жуулчлал хөгжүүлэх төв, Халхгол сумын ЗДТГ-т байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч, Ялалт багт аймгийн БОГ-ын байгаль хамгаалагч зэрэг бие даасан байгууллага, албан хаагч нар ажиллаж байгаа нь УИХ-ын 2024 оны 54 дүгээр тогтоолын дагуу "бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэхэд тавих хяналтыг сайжруулж, төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсөвт багтаан шийдвэрлэх" арга хэмжээг авч ажиллаагүй байна.

**Аймгийн ИТХ-д өгсөн зөвлөмж:** Төсвийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэхэд тавих хяналтыг сайжруулж, байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах.

4. Нягтлан бодох бүртгэлийн талаар

**Илрүүлэлт 4:** "Буйр нуурын экосистемийг хамгаалах, аялал жуулчлалыг хөгжүүлэх төв" ОНӨААТҮГ нь байгууллагын онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Төрийн банкнаас өгсөн 3.0 сая төгрөгийн урамшууллыг байгууллагын	1	3,000.0			1	3,000.0							

**Буйр нуурын экосистемийг хамгаалах, аялал жуулчлал хөгжүүлэх төв ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

хамтын санд гэж зарцуулсан												
Бараа материалын хагас жилийн тооллогыг хийгээгүй байна	1	6,183.5			1	6,183.5						
байгууллагын онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллаагүй	1	0					1	0				
байгууллагын 3 албан хаагч нь ажлын цагийн бүртгэлийг гар утсаар дамжуулан бүртгүүлдэг тул үйл ажиллагааг хэвийн чиг үүргийн дагуу үр дүнтэй зохион байгуулж байгаа нь эргэлзээтэй байна	1	0					1	0				
Тус байгууллага нь өөрийн орлогыг төлөвлөдөггүй,	1	0					1	0				
төсвийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэхэд тавих хяналтыг сайжруулж, төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх,чиг үүргийн давхардлыг арилгах	1						1	0				
<b>Нийт дүн</b>	<b>6</b>	<b>9,183.5</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>9,183.5</b>	<b>4</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>